



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 04 өдөр


Дугаар А/114

Хужирт сум

“Эрүүл сүрэгтэн” батламж олгох туршилтын
хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11 дэх заалт, аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн “Эрүүл сүрэгтэн батламж олгох туршилтын хөтөлбөр хэрэгжүүлэх тухай” А/21 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд зорилтот өрхийн үхэр сүрэгт батламж олгох ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, төлөвлөгөөг хоёрдугаар, зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Бруцеллёз өвчнөөс эрүүлийг баталгаажуулах ажлын талаарх мэдээллийг малчдад хүргэж ажиллахыг багийн Засаг дарга нарт, товлосон хугацаанд үхэр сүргээ бүрэн хамруулахыг мал бүхий иргэд, малчдад тус тус үүрэг болгосугай.
3. Зорилтот өрхийн үхэр сүргээс баталгаажуулах шинжилгээг бүрэн авч, шинжлэх ажлыг стандартын дагуу зохион байгуулахыг “Гуахарз” Мал эмнэлэг үржлийн нэгжийн эмч (Д.Даваасүрэн), (О.Дэлгэрсайхан), “Гонир манал” Мал эмнэлэг үржлийн нэгжийн эмч (Ш.Байгалмаа), малчдад сургалт зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн Улсын байцаагч Б.Ичинхоролцэвэлмаа нарт тус тус үүрэг болгосугай.
4. Дээрх ажилд шаардагдах зардлыг малын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээнд төсөвлөсөн зардлаас зарцуулахыг Нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д даалгасугай.
5. Зохион байгуулсан ажлын тайланг 2023 оны 09 дүгээр сарын 25-ны дотор аймгийн Мал эмнэлгийн газарт хугацаанд нь хүргүүлэхийг Мал эмнэлгийн Улсын байцаагч (Б.Ичинхоролцэвэлмаа)-д үүрэг болгосугай.



ОРЛОГЧ

Б.ДЭМБЭРЭЛ

622301233

D:My doc; Zahiramj 2023